

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2006 оны 2 дугаар сарын
15-ны өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ
тогтоосон эрх зүйн актын тухай

Хорооны 2006 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн хуралдааны шийдвэр,
“Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай” хуулийн 6.1.2 дахь заасныг
удирдлаг болгон ТОГТООХ нь:

1.”Банк бус санхүүгийн байгууллагын Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай” хуульд заасан болон “Хоршооны тухай” хуульд заасан Хадгаламж, зээлийн үйл ажиллагааны талаар Монголбанкнаас; Үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллага, оролцогчдын “Үнэт цаасны зах зээлийн тухай” хуульд заасан үйл ажиллагааны талаар Үнэт цаасны хорооноос; Даатгагч болон даатгалын төлөөлөгч, зуучлагч, хохирол үнэлэгчийн “Даатгалын тухай” болон “Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай” хуульд заасан үйл ажиллагааны талаар холбогдох байгууллагуудаас батлан мөрдөж байгаа дүрэм, журам, заавар, шалгуур үзүүлэлт зэрэг нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон эрх зүйн актыг цаашид боловсронгуй болгон шинэчлэн батлах хүртэл эрх залгамжлалын журмаар хүчин төгөлдөр мөрдөх нь зүйтэй гэж үзсүгэй.

2.Дагаж мөрдөж байгаа нийтлэг хэм хэмжээ тогтоосон эрх зүйн актыг “Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай” болон бусад хуульд нийцүүлэн шинэчлэн боловсруулж, 2006 оны эхний хагас жилд багтаан хорооны хуралдаанд оруулж батлуулах арга хэмжээ авахыг Ажлын албанд даалгасугай.

3.Энэ тогтоолыг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Ажлын албаны даргад үүрэг болгосугай.

ДАРГА

Д.БАДРАА